

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## Агуулга

1. Аудитын гэрчилгэ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1 Оршил.....	4
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	5
2.8 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9 Орлого, зардлын талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	7
2.12 Шилэн дансны мэдээлэл .....	7
2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	7
2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал.....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	13
4.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	14
4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	15
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	17

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

“НАЛАЙХЫН ДУЛААНЫ СТАНЦ”  
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Ц.МИНЖИНХҮҮ ТАНАА

2020 03.13 № 06/776  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 дахь заалтад заасны дагуу “Налайхын дулааны станц” ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

“Налайхын дулааны станц” ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Налайхын дулааны станц” ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

“Налайхын дулааны станц” ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

*Ц. Наранчимэг*

Ц.НАРАНЧИМЭГ



## **2. Аудитын тайлан**

### **2.1 Оршил**

“Налайхын дулааны станц” ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг “Налайхын дулааны станц” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Ц.Минжинхүү танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн зардлын болон балансын данстай холбоотой зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Налайхын дулааны станц” ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Налайхын дулааны станц” ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, СТОУС түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Налайхын дулааны станц” ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 17-наас 2020 оны 03 дугаар сарын 03-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Лидер экаунт аудит” ХХК-ийн ахлах аудитор Д.Лхамсүрэн хариуцаж хэрэгжүүлэв.

“Налайхын дулааны станц” ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланг “Лидер экаунт аудит” ХХК-д 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 203 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

### **Эрхэм зорилго:**

“Налайхын дулааны станц” ТӨХК нь хэрэглэгчээ дээдлэн, дэвшилтэт технологид түшиглэсэн дулааны эрчим хүчний үр ашигтай үйлдвэрлэл явуулах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллаж байна.

### **Үйл ажиллагааны чиглэл:**

Тус компани нь Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 04/2009 дугаар тогтоолоор олгосон дулаан үйлдвэрлэх, 2016 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 46/2013, 47/2013 дугаар тогтоолуудаар дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлүүдийн хүрээнд Налайх дүүргийн төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон 2880 айл өрх, 31 төсвийн байгууллага, 260 аж ахуйн нэгж байгууллагыг дулааны эрчим хүчээр ханган ажиллаж байна.

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

“Налайхын дулааны станц” ТӨХК нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Unicus” программ хангамж ашигладаг байна.

“Налайхын дулааны станц” ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар “Налайхын дулааны станц” ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 9 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## **2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг

сонгож, эрсдэлийн түвшнийг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлт болох 2019 оны 3 дугаар улирлын байдлаарх нийт зардлын дүн 3,546.7 сая төгрөгөөс тооцон 70.9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны нийт зардлын 2 хувь буюу 104.3 сая төгрөгөөр тогтоосон нь 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн суурь үзүүлэлтээс тооцсонтой холбоотой болно.

## 2.8 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Налайхын дулааны станц” ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 247.5 сая төгрөгөөр буюу 2.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, өглөгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	204.8	95.7	(109.1)
Авлага	377.9	442.1	64.2
Бараа материал	129.3	183.1	53.7
Урьдчилж төлсөн зардал/тооцоо		6.9	6.9
Үндсэн хөрөнгө	7,866.8	7,600.9	(265.8)
Биет бус хөрөнгө	1,853.9	1,856.5	2.5
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>10,432.8</b>	<b>10,185.4</b>	<b>(247.4)</b>
Өглөг	1,229.2	1,140.9	(88.3)
Урьдчилж орсон орлого			
<b>Өр төлбөрийн дүн</b>	<b>1,229.2</b>	<b>1,140.9</b>	<b>(88.3)</b>
Өмч: Төрийн	6,373.9	6,373.9	-
Хуримтлагдсан ашиг	(1,718.3)	(1,877.5)	(159,133.0)
<b>Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	<b>10,432.8</b>	<b>10,185.4</b>	<b>(247.4)</b>

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл буурсан нь нүүрсний зардал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 64.2 сая төгрөгөөр өссөн нь шинээр байгуулагдсан “Шинэ Налайх” хорооллын дулааны төлбөр болох 64.2 сая төгрөг төлөгдөөгүйтэй холбоотой байна. Тайлант оны эцэст нийт авлагын үлдэгдэл 442.1 сая төгрөг байгаагийн 129.1 сая төгрөг нь аж ахуй нэгж байгууллагуудаас, 298.8 сая төгрөг нь айл өрхүүдээс, 14.1 сая төгрөг нь төсөвт байгууллагаас авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 53.7 сая төгрөгөөр өссөн нь зуухны сэлбэгийн материалын үлдэгдэл өссөнөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 290 дүгээр тогтоолоор 139.9 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,140.8 сая төгрөг байгаагийн 499.7 сая төгрөг буюу 43.8 хувь нь нүүрсний өглөг, 220.2 сая төгрөг буюу 19.3 хувь нь нүүрс тээвэрлэлтийн өглөг, 292.1 сая төгрөг буюу 25.6 хувь нь бэлтгэн нийлүүлэгчийн өглөг, 117.5 сая төгрөг буюу 10.3 хувь татварын өглөг, 11.4 сая төгрөг буюу 1.0 хувь нь бусад өглөг байна.

## **2.9 Орлого, зардлын талаарх тайлбар, тодруулга**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д заасны дагуу хөрөнгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, удирдлага нь энэ хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасан аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх, үүргийг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

“Налайхын дулааны станц” ТӨХК-ийн тайлант онд 4,928.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны зардалд 5,037.9 сая төгрөгийг зарцуулж, 109.7 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ. Нийт орлогын 3,720.6 сая төгрөг нь үндсэн үйл ажиллагааны орлого, 4.9 сая төгрөг нь түрээсийн орлого, 10.6 сая төгрөг нь хүүгийн орлого, 91.5 сая төгрөг нь бусад орлого, 1,100.4 сая төгрөг нь улсын төсвийн санхүүжилтийн орлого байна. Нийт зардлын 4,884.1 сая төгрөг нь борлуулалтын өртөг, ерөнхий ба удирдлагын зардал 153.8 сая төгрөг байна.

2019 онд зорилтот түвшний орлогын төлөвлөгөөнд нийт зардлыг 5,393.0 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 5,210.2 сая төгрөг болж, зардлыг 182.8 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулж, 114.3 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, ашгийн төлөвлөгөөг 296.1 сая төгрөгөөр бууруулж ажиллажээ.

## **2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 9 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 5 эрсдэл тодорхойлж нийт 9 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 64.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## **2.11 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй.

## **2.12 Шилэн дансны мэдээлэл**

“Налайхын дулааны станц” ТӨХК-ийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 62 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

## **2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 43.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 3 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.



## **2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид “Налайхын дулааны станц” ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

### **“Зөрчилгүй” дүгнэлт**

“Налайхын дулааны станц” ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, НББОУС, СТОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Авлагын талаар**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

- “Тэлмэн констракшн” ХХК-аас авах он дамжсан 64.2 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна. Энэ нь эрх үүрэг, оршин байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 8-д “өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч, үлдэгдлийг тооцсон байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

- Стандарт, хууль, тогтоомж зөрчигдөх эрсдэлтэй.

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

- Авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

- Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

#### **3.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар**

##### **3.2.1 Илрүүлэлт:**

- Нягтлах бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2015 оноос хойш шинэчлээгүй байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-д “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн

бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалттай нийцэхгүй байна.

#### **3.2.2 Эрсдэл:**

- Стандарт, хууль, тогтоомж зөрчигдөх эрсдэлтэй.

#### **3.2.3 Өгсөн зөвлөмж:**

- Нягтлах бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж, мөрдөж ажиллах.

#### **3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

- Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

### **3.3 Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийн талаар**

#### **3.3.1 Илрүүлэлт:**

- Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийг 0.1 сая төгрөгөөр дутуу тооцсон. Энэ нь үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д “Албан татвар төлөгчийн энэ хуулийн...орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

#### **3.3.2 Эрсдэл:**

- Стандарт, хууль, тогтоомж зөрчигдөх эрсдэлтэй.

#### **3.3.3 Өгсөн зөвлөмж:**

- Хуульд заасны дагуу татварын хөнгөлөлтийг зөв тооцох.

#### **3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

- Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 06 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>2018 оны 12-р сарын 31</u>	<u>2019 оны 12-р сарын 31</u>
<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	204,845,539.80	95,764,820.72
Дансны авлага	377,865,724.00	442,064,387.89
Татвар, НДШ – ийн авлага		
Бусад авлага		
Бараа материал	129,300,057.40	183,056,727.91
Урьдчилж төлсөн зардал/тооцоо		6,990,843.00
Хувь хүнээс авах авлага		
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>712,011,321.20</b>	<b>727,876,779.52</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
Үндсэн хөрөнгө	7,866,834,300.33	7,600,968,791.37
Биет бус хөрөнгө	1,853,990,250.00	1,856,524,772.77
Бусад эргэлтийн хөрөнгө		
Бусад эргэлтийн бус хөрөнгө		
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>9,720,824,550.33</b>	<b>9,457,493,564.14</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>10,432,835,871.53</b>	<b>10,185,370,343.66</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>Өр төлбөр</b>		
<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
Дансны өглөг	1,140,892,808.39	1,012,443,637.44
Цалингийн өглөг		
Татварын өр	86,091,293.93	29,840,559.73
НДШ - ийн өглөг		42,577,483.69
Банкны богино хугацаат зээл		
Бусад богино хугацаат өр	2,235,423.81	11,206,723.42
Урьдчилж орсон орлого		
Бусад өглөг		
Ногдол ашгийн өглөг		44,818,650.23
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>1,229,219,526.13</b>	<b>1,140,887,054.51</b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
Урт хугацаат зээл		
Бусад урт хугацаат өглөг		

<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	-	-
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>1,229,219,526.13</b>	<b>1,140,887,054.51</b>
<b>Эздийн өмч</b>		
Өмч: Төрийн	6,373,866,456.47	6,373,866,456.47
Хувийн		
Хувьцаат		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,727,654,260.64	2,727,654,260.64
Эздийн өмчийн бусад хэсэг	1,820,434,000.00	1,820,434,000.00
Хуримтлагдсан ашиг	(1,718,338,371.71)	(1,877,471,427.96)
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>9,203,616,345.40</b>	<b>9,044,483,289.15</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>10,432,835,871.53</b>	<b>10,185,370,343.66</b>

#### 4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>2018 оны 12-р сарын 31</u>	<u>2019 оны 12-р сарын 31</u>
<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>3,657,579,108.54</b>	<b>3,720,629,235.14</b>
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	4,170,798,320.08	4,884,133,214.31
<b>Нийт ашиг ( алдагдал)</b>	<b>(513,219,211.54)</b>	<b>(1,163,503,979.17)</b>
Түрээсийн орлого	3,698,181.83	4,990,909.10
Хүүний орлого	10,398,634.09	10,582,869.37
Бусад орлого	97,521,212.36	91,479,424.85
Борлуулалт, маркетингийн зардал		
Ерөнхий ба удирдлагын зардал	120,512,494.54	153,803,322.65
Санхүүгийн зардал		
Бусад зардал		
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
Бусад ашиг (алдагдал)	1,031,325,268.94	1,100,460,844.55
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>509,211,591.14</b>	<b>(109,793,253.95)</b>
Орлогын татварын зардал	61,025,088.81	4,521,152.07
<b>Татвар дараах ашиг (алдагдал)</b>	<b>448,186,502.33</b>	<b>(114,314,406.02)</b>
<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>448,186,502.33</b>	<b>(114,314,406.02)</b>
<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
Бусад олз (гарз)		
<b>Орлогын нийт дүн</b>	<b>448,186,502.33</b>	<b>(114,314,406.02)</b>
<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>	<b>-</b>	<b>-</b>

### 4.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт
<b>2017 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл</b>	3,392,872,148.47	531,843,250.00	2,980,994,308.00	(2,680,301,974.04)	<b>4,225,407,732.43</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				513,777,100.00	<b>513,777,100.00</b>
<b>Залруулсан үлдэгдэл</b>					
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				448,186,502.33	<b>448,186,502.33</b>
Бусад дэлгэрэнгүй орлого					
Өмчид гарсан өөрчлөлт	2,980,994,308.00		(2,980,994,308.00)		
Зарласан ногдол ашиг					
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		2,195,811,010.64	1,820,434,000.00		<b>4,016,245,010.64</b>
<b>2018 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл</b>	<b><u>6,373,866,456.47</u></b>	<b><u>2,727,654,260.64</u></b>	<b><u>1,820,434,000.00</u></b>	<b><u>(1,718,338,371.71)</u></b>	<b><u>9,203,616,345.40</u></b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(44,818,650.23)	<b>(44,818,650.23)</b>
<b>Залруулсан үлдэгдэл</b>					
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(114,314,406.02)	<b>(114,314,406.02)</b>
Бусад дэлгэрэнгүй орлого					
Өмчид гарсан өөрчлөлт					
Зарласан ногдол ашиг					
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
<b>2019 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл</b>	<b><u>6,373,866,456.47</u></b>	<b><u>2,727,654,260.64</u></b>	<b><u>1,820,434,000.00</u></b>	<b><u>(1,877,471,427.96)</u></b>	<b><u>9,044,483,289.15</u></b>

#### 4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>2018 оны 12-р сарын 31</u>	<u>2019 оны 12-р сарын 31</u>
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>5,457,258,654.04</b>	<b>5,455,492,767.88</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	4,022,585,425.26	4,029,180,792.88
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	331,901.00	
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	16,420,189.00	5,146,975.00
Буцаан авсан албан татвар		
Татаас, санхүүжилтийн орлого	1,400,000,000.00	1,400,000,000.00
Бусад мөнгөн орлого	17,921,138.78	21,165,000.00
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>5,176,778,266.60</b>	<b>5,284,843,806.33</b>
Ажиллагчдад төлсөн	1,181,842,119.63	1,458,364,105.78
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	368,036,484.69	447,691,016.66
Бараа материал худалдан авахад төлсөн	100,222,436.00	188,486,233.00
Ашиглалтын зардалд төлсөн	783,192,215.90	694,352,601.19
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,732,162,256.95	1,617,774,375.79
Хүүний төлбөрт төлсөн		
Татварын байгууллагад төлсөн	762,420,838.86	555,500,770.49
Даатгалын төлбөрт төлсөн	95,400.00	308,184.00
Бусад мөнгөн зарлага	248,806,514.57	322,366,519.42
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>280,480,387.44</b>	<b>170,648,961.55</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>10,398,634.09</b>	<b>10,582,869.37</b>
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
Хүлээн авсан ноогдол ашиг		
Хүлээн авсан хүүний орлого	10,398,634.09	10,582,869.37
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>166,915,214.36</b>	<b>290,312,550.00</b>
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	157,665,214.36	254,494,300.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	2,700,000.00	15,045,750.00
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	6,550,000.00	20,772,500.00
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(156,516,580.27)</b>	<b>(279,729,680.63)</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		



<b>Мөнгөн орлогын дүн</b>	-	-
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг		
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	-	-
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал		
Төлсөн ногдол ашиг		
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<u>-</u>	<u>-</u>
Валютын ханшийн зөрүү	-	-
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>123,963,807.17</b>	<b>(109,080,719.08)</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	80,881,732.63	204,845,539.80
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b><u>204,845,539.80</u></b>	<b><u>95,764,820.72</u></b>

## 5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2019.12.31	Аудитын нэр:	<b>“Налайхын дулааны станц” ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит</b>	Аудитын код: САГ-2020/42/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>“Налайхын дулааны станц” ТӨХК</b>		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	“Тэлмэн констракшн” ХХК-аас авах он дамжсан авлагыг барагдуулаагүй байна.	64.2	Зөвлөмж	Гүйцэтгэх захирал	Ц.Минжинхүү
				Ерөнхий нягтлан бодогч	Д.Бадамлянхуа
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2015 оноос хойш шинэчлээгүй байна.		Зөвлөмж	Гүйцэтгэх захирал	Ц.Минжинхүү
				Ерөнхий нягтлан бодогч	Д.Бадамлянхуа
3	Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийг дутуу тооцсон.	0.1	Зөвлөмж	Гүйцэтгэх захирал	Ц.Минжинхүү
				Ерөнхий нягтлан бодогч	Д.Бадамлянхуа
<b>Дүн</b>		<b>64.3</b>			



